

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН
/Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар/

2022.10.24

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан нөхцөл тайлбар)
				Он	Түвшин		
НЭГ.ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ							
Зорилго 2. Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн орчныг бүрдүүлнэ.							
1	2.5.4.Айл өрхийг цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд үе шаттайгаар холбож, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлнэ.	УТХО 1,500.0 АОНХС ХХО 40.0	Сүмбэр сумын 1-р багийн айл өрхийг цэвэр, бохир усны шугам, дулаанд холбоно. Шинээр сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болсон өрхийн тоо Цэвэр усны шинэчлэгдсэн шугамд холбогдсон өрхийн тоо	2022	14 айл өрх	80 өрх 20 өрх 360 өрх	<p>1.Сүмбэр сумын ЗДТГ-ын захиалгаар Сүмбэр сумын 3 дугаар багт шинэ суурьшлын бүсэд 400м цэвэр усны шугам бш огтолгоо авах худаг, ус түгээх ухаалаг худаг нэг ширхгийг хийлгэхээр “Стронг найс констракш”н ХХК-тай гэрээ байгуулж 100% гүйцэтгэн байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн</p> <p>2. Шивээговь сумын цэвэр усны төв магистрал шугамын өргөтөл шинэчлэлийн ажлыг “Стронг найс констракш”ХХК 185,8 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр гүйцэтгэн байнгын ашиглалтад хүлээлгэн өгөөд байна.</p> <p>3.Шивээговь сумын нийтийн эзэмшлийн орон сууцны 6,7 байрны зоорийн давхарын дулаан, цэвэр ус, бохирын шугам сүлжээний засварын ажлыг “Такамаса” ХХК 153,0 сая төгрөгийн өртгөөр хийж гүйцэтгэн байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. Шугам сүлжээний шинэчлэлд 150 айл өрх хамрагдсан байна.</p> <p>4.БХБЯ захиалгатай Сүмбэр сумын 1 дүгээр багийн айл өрхийн бохир усыг төлөвлөрсөн бохир усны шугамд холбох ажлыг “Мөнхзүмбэр” ХХК 700,0 сая төгрөгийн өртгөөр хийж гүйцэтгэж байна. 2022 оны ажлын гүйцэтгэл 100% хийгдсэн. Дээрх инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэнээр 70 ААН, 408 айл өрхийн бохир усыг татан зайлуулах боломж бүрдсэн.</p> <p>5.Сүмбэр сумын 3 дугаар багийн нийтийн эзэмшлийн орон сууцны 6-р байрны зоорийн давхарын дулаан, цэвэр ус, бохирын шугам сүлжээний засварын ажлыг “Ус-Ду” ОНӨААТҮГ 103,0 сая төгрөгийн өртгөөр хийж гүйцэтгэсэн. Шугам сүлжээний шинэчлэлд 79 айл өрх хамрагдсан байна. Ингэснээр иргэдийн амьдрах орчныг сайжруулж, орон сууцны ашиглалтын нөхцлийг нэмэгдүүлсэн.</p> <p align="right">Хэрэгжилт 90 хувь</p>
Зорилго 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлого, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэн, амьдралын чанарыг дээшлүүлнэ.							
2	3.2.1. 540 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.	ХХО	Ашиглалтад орох орон сууцны айл өрхийн тоо	2022	2	351	<p>1.Сүмбэр сумын 3-р багт 315 айлын орон сууц бариулахаар орон нутгаас газрын асуудлыг бодлогоор дэмжиж шийдвэрлэсэн. Сүндэр хотхон барилгын ажлыг гүйцэтгэхээр “Юникел тауэр” ХХК шалгарч ажлаа эхлүүлээд байгаа бөгөөд 2023 оны 2-р улиралд багтаан 126 айлын орон сууцыг ашиглалтад өгөхөөр төлөвлөгөөтэй ажиллаж байна.</p>

							2. Сүмбэр сумын Найрамдал хотхонд 36 айлын орон сууцны барилгын ажлыг орон нутгийн Осо констаркшн ХХК 1,2 дугаар давхарын цугтамал төмөр бетон каркасын ажлыг гүйцэтгэж байна. Мөн орон сууцны гадна цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд “Шинээр баригдах хотхоны гадна цахилгаан хангамж 6кв ЦДАШ, 2Х630 кВа хаалттай дэд өртөө”-ний ажлыг орон нутгийн төсвийн 240,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Осо-констракшн”ХХК гүйцэтгэсэн байна. Байгууллагын зүгээс шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж, ажлын явцад үе шатны ажилд зөвлөгөө зөвлөмж өгч хамтран ажиллаж байна. Хэрэгжилт 90 хувь
3	3.2.2. Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжиж, бетон зуурмаг, вакум цонх, бетон эдлэл зэрэг барилгын материалын үйлдвэрлэлийг бэхжүүлнэ.	ХХО	Барилгын материалын үйлдвэр, цехийн тоо	2022	3	5	Аймгийн хэмжээнд барилгын материалын үйлдвэрлэл эрхэлж буй 5 иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг авч мэдээллийн санд бүртгэсэн.Үүнд: 1. “Илчит сансар”ХХК ф1000-н кольцо 200ш, ф1500-н кольцо 160ш, ф700-н кольцо 100ш, L4-н лотки 30ш, L2-н 80ш, ф1500 ташуу таг 100ш, ф1000-н ташуу таг 120ш 2. “Эрин зууны холбоос” ХХК дулаан блок 5000ш, нүхтэй блок 10000ш 3. Сүмбэр сумын иргэн Н.Ганхуяг бетон евро хашаа 1300м 4. Сүмбэр сумын иргэн Э.Амарсайхан бетон үйлдвэрлэлийн зуурмаг 850м3 5. “Алтан булаг уул” ХХК 2500м3 бетон зуурмаг зэрэг бүтээгдэхүүнийг тус тус үйлдвэрлэсэн байна. Бетон зуурмаг болон блок үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа “Алтан булаг уул” ХХК, “Эрин зууны холбоос” ХХК зэрэгт холбогдож үйлдвэрлэлийн зөвшөөрөл авах талаар зөвлөгөө өгч, холбогдох мэдээллийг ирүүлэхийг мэдэгдсэний дагуу “Эрин зууны холбоос” ХХК үйлдвэрлэлийн тохирлын гэрчилгээг авсан үр дүнтэй байна. үүний үр дүнд чанарын шаардлага хангасан бетон зуурмаг, блок үйлдвэрлэгдэж хэрэглэгчдэд хүрч байна. Хэрэгжилт 100 хувь
ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА							
Зорилго 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлого, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэн, амьдралын чанарыг дээшлүүлнэ							
Газрын харилцаа							
3.5. Аймгийн хэмжээнд газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ							
4	3.5.1. Хаягжилтын ажлыг үргэлжлүүлэн мэдээллийн санг хөтөлнө	Үйлажил лагаа	Хаягийн мэдээлл засвар сумын тоо, Ажлын гүйцэтгэлийн хувь	2021-2025	0 0	3 90	Аймгийн хэмжээний зам, гудамж, талбайг зураглах, нэгж талбар, барилгад хаяг олгох, засварлах ажлыг газрын даргын 2021 оны А/07 дугаар тушаалын дагуу 2021 онд хаягийн мэдээллийн санг 96.1 хувийн биелэлттэйгээр засварлан ажиллаж холбогдох мэдээ, тайланг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлсэн. Үүнд: • Сүмбэр сум – 7408 нэгж талбар, 1996 барилга • Баянтал сум- 1688 нэгж талбар, 143 барилга

							<ul style="list-style-type: none"> • Шивээговь сум- 2364 нэгж талбар, 230 барилга тус тус бүртгэж оруулсан. <p>Мөн үе шаттайгаар хаягийн мэдээллийн санд орц, гарцыг тодорхойлон ажиллаж байгаа бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар 92,6%-ийн гүйцэтгэлтэй орц, гарцыг тодорхойлон ажилласан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Сүмбэр сум-7333 нэгж талбар, 1823 барилга • Баянтал сум-1642 нэгж талбар, 141 барилга • Шивээговь сум-2265 нэгж талбар, 237 барилгын орц, гарцыг тус тус тодорхойлон ажилласан. <p>Хаягийн мэдээллийн сангаар дамжуулан жилийн эцсийн байдлаар нийт 284 иргэн, хуулийн этгээдэд шинээр хаяг олгосон. Үүний үр дүнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдийн газрын хаяг дугаар давхардахгүй байхаас гадна хаягийн нэгдсэн нэг системд бүртгэгдэх зэрэг ач холбогдолтой байна.</p> <p>Хэрэгжилт: 100 хувь</p>
5	3.5.2. Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий болж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ		Газрын мониторингийн цахим системд программ хангамжийг хөгжүүлнэ.	2021-2025	90	100	<p>Газар ашиглалт, газрын мониторингийн цахим системийг 2020 оны 9 дүгээр сараас эхлэн хэрэглээнд нэвтрүүлэн үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж хэвшсэн. 2021 оны 10 дугаар сараас хөгжүүлэлт хийгдэж дууссан e-gazar.gov.mn сайтын газрын мониторингийн цахим системээр дамжуулан газрын захиалгат хянан баталгааны мэдэгдэх хуудсыг иргэн, аж ахуйн нэгжид өгөх болон баталгаажсан тайлан дүгнэлтээ цахимаар авах боломжийг бүрдүүлсэн. Аймгийн хэмжээнд захиалгат хянан баталгаа хийлгэх шаардлагатай 1181 нэгж талбарын судалгааг гаргаж иргэд аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдэх хуудсыг тараах ажлыг эрчимжүүлэн зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Сүмбэр суманд- 909 нэгж талбар - Баянтал суманд- 92 нэгж талбар - Шивээговь суманд- 180 нэгж талбарт мэдэгдэх хуудас хүргүүлсэн. <p>Үүний үр дүнд 503 нэгж талбарт захиалгат хянан баталгааг хийлгэх мэдэгдэл хүргүүлж, 165 нэгж талбарын хянан баталгааг цахимаар ирүүлснийг баталгаажуулаад байна.</p> <p>Хэрэгжилт 100 хувь</p>
6	3.5.3. Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн үйл ажиллагааг сайжруулна	Үйлажил лагаа	Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн нэгдсэн системийн үйл ажиллагааг орон нутагт явуулах, нэгж талбарт ногдуулалтыг үүсгэж, нэхэмжлэхийг татварын систем рүү илгээх.	2021-2025	1416 нэгж талбар	1436 2872	<p>Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татварын нэгдсэн системийг 2020 оноос нэвтрүүлж үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байна. 2022 онд газрын төлбөрийн системээр дамжуулан Газрын кадастрын цахим системд бүртгэлтэй хүчинтэй гэрээг үндэслэн нийт 10998 нэгж талбарт татвар, төлбөрийн ногдуулалтыг үүсгэж татварын системд илгээж ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 2046 нэгж талбарт газрын төлбөрийн ногдуулалт - 8952 нэгж талбарт газрын татварын ногдуулалт үүсгэсэн. <p>Үүний үр дүнд Татварын хэлтэс газрын татвар, төлбөрийг үүсгэсэн нэхэмжлэхийн дагуу хураах ажлыг хэрэгжүүлж байна. 2022 оны 10 дугаар сарын 24-ний байдлаар 211,8 сая төгрөгийн төлбөрийг төвлөрүүлсэн байна.</p> <p>Хэрэгжилт 100 хувь</p>

НАЙМ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

Зорилго 8. Орон нутгийн онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, аймаг, сумдын төвийн дэд бүтцийг сайжруулж, орон нутгийг хөгжүүлнэ

Дэд бүтэц

8.1. Аймаг, сумдын төвийн дэд бүтцийг сайжруулна

7	8.1.8.Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний өөрчлөлт болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хийлгэнэ		Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх ажлын гүйцэтгэлийн хувь	2022	30	70	Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол шинэчлэлийн ажлыг орон нутгийн төсвийн 200,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэхээр тендер шалгаруулалтын ажлыг зарласан байна. Төлөвлөгөөг хийлгэхэд шаардагдах төсвийг тодруулах, шаардлагатай талбайн хэмжээ болон ажлын даалгаварыг батлахад хамтран ажилласан. <p align="right">Хэрэгжилт 100 хувь</p>
8	8.1.9.Сүмбэр сумын төвд дахин төлөвлөлтийг хэрэгжүүлнэ		Дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл	2022	Дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэх шийдвэр гарсан.	Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, гэрээ байгуулна.	Сүмбэр сумын 1 дүгээр багт дахин төлөвлөлтийн ажлыг хэрэгжүүлэхээр 3 байршлыг төлөвлөж 2 байршлын ажлыг эхлүүл Багш нарын байрны оршин суугчидтай 2021.03.11-ний өдөр уулзалтыг зохион байгуулж, иргэдээс хүсэлтийг хүлээн авах ажлыг зохион байгуулсан. Нийт 28 айл өрхөөс 11 өрх дэмжсэн саналыг өгсөн. Зураг төслийн “Жаргалант хийц” ХХК-тай гэрээ байгуулан 18,0 сая төгрөгийн төсөвт өртгөөр зураг төслийг гүйцэтгүүлсэн бөгөөд Монголын архитекторын эвлэлийн газар хянагдаж байна. 2022 онд дахин төлөвлөлтийн ажлын гадна инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг шийдвэрлэх талаар байгууллагын даргын 2022.03.09-ний өдрийн 01/12 албан бичгээр АЗДТГ-т 2023 оны улсын төсөвт тусгуулах талаар саналыг хүргүүлсэн. Мөн байгууллагын зүгээс дахин төлөвлөлтийн ажлын хил зааг батлах, нийт 70 айл өрхөд танилцуулга хийх, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлах зэрэг ажлуудад АЗДТГ-ын ХБТХОХ-тэй хамтран ажилласан. <p align="right">Хэрэгжилт 90 хувь</p>
9	8.1.10.Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилтыг сайжруулж, аймаг сумдын төвд дугуйн зам, явган хүний зам, гудамжны гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлнэ		Шинээр хийгдэх явган замын хэмжээ, м2 Шинээр хийгдэх гэрэлтүүлгийн тоо Шинээр хийгдэх дугуйн замын урт, км	2022	2.8	2900м2 121ш 1050м2	-Сүмбэр сумын ЗДТГ-ын захиалгаар 70,0 сая төгрөгийн төсөвт өртгөөр Сүмбэр сумын 3-р багт Баянбулагийн 1-10 хүртэлх эгнээний 100 ширхэг гэрэлтүүлгийн толгой угсрах ажлын гүйцэтгэгчээр “Од жи Од” ХХК шалгарч ажлыг 100% гүйцэтгэн байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. - Сүмбэр сумын 2-р багийн Бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил АЗДТГ захиалгатай “Хүслэн хийморь” ХХК хийж гүйцэтгэн байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. Тус тохижилтын ажилд хэсэгчилэн хийгдсэн 16 ширхэг гэрэлтүүлэг,2900м2 явган зам, резин хавтан 254м2, бетон талбай 151 м2, дугуйн зам 1050м2 тус тус хийгдсэн. -Шивээговь сумын ЗДТГ-ын захиалгаар 59,0 сая төгрөгийн төсөвт өртгөөр сумын гудамж тайлбайд гэрэлтүүлэг нэмэх, гэрэлтүүлгийн чимэглэл хийх ажлын гүйцэтгэгчээр “Од жи Од” ХХК шалгарч 30 ширхэг гэрэлтүүлгийг хийж гүйцэтгэн, байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх шатандаа байна. Дээрхи ажлуудад захиалагчийн хяналтыг 100% хэрэгжүүлэн ажилласан. <p align="right">Хэрэгжилт 90 хувь</p>

10	8.1.11.Шинээр өмчлөлд олгосон газруудад цахилгаан татаж, гэр хорооллын цахилгаан хангамжийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ		Нарангийн гэр хороололд цахилгаан татах ажлын гүйцэтгэл Бурхантын гэр хороололд цахилгаан татах ажлын гүйцэтгэл Тэрэгтийн гэр хороололд цахилгаан татах ажлын гүйцэтгэл	2022		6/0.4кВ агаарын шугам,КТПН /иж бүрэн дэд өртөө	-Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Тэрэгтийн суурьшлын бүсийн айл өрхүүдийг цахилгаанд холбохоор 239,2 сая төгрөг тусгагдсан бөгөөд ажлын гүйцэтгэгчээр “Жи пауэр” ХХК шалгарч ажлыг 100% хийж гүйцэтгэн байнгын ашиглалтанд хүлээлгэн өгсөн. - Сүмбэр сумын ОНХС-н хөрөнгө оруулалтаар Бурхантын гудамжинд бүсийн цахилгаан хангамжийн ажлыг 141,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Нуклон” ХХК гүйцэтгэсэн. Ажлын хүрээнд 60 айл өрх цахилгаанаар хангагдах боломжтой болсон. Дээрхи ажлуудад захиалагчийн хяналтыг 100% хэрэгжүүлэн ажилласан. Хэрэгжилт 90 хувь
----	--	--	---	------	--	--	---

БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

№	Арга хэмжээний тоо	Үүнээс:						Үнэлэх боломжгүй	Биелэлтийн хувь
		Хэрэгжих шатандаа							
		100%	90%	70%	50%	30%	0%		
1	10	5	5	-	-	-	-	95%	

ГАЗРЫ ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР